

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ДУГААР	151021-18
ХАВСРАЛТ	2
ОГНОО	2021 оны 11-р сарын 17-ны өдөр
УТГА	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооноос Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК (“Компани”)-ийн нийтэд санал болгон үнэт цаасны анхдагч арилжаа амжилттай болсонд тооцож, хоёрдогч зах зээлийн арилжааг 2021 оны 11-р сарын 12-ны өдрөөс эхлүүлэх зөвшөөрлийг олгосонтой холбогдуулан Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (“Хурал”)-ыг зарлан хуралдуулах асуудлыг хэлэлцээд Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дох заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.4, 62.1.7 дох заалт, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын холбогдох заалтууд, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 10-р сарын 13-ны өдрийн 430 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хурлыг 2021 оны 12-р сарын 28-ны өдрийн 10:00 цагт <https://hural.cumongol.mn> веб хаягаар Zoom платформ ашиглан цахим хэлбэрээр хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Хурлаар дараах асуудлыг хэлэлцэхээр шийдвэрлэсүгэй. Үүнд:
 - (i) Компанийг хувьцаат компани болгох замаар хэлбэрийг өөрчлөх;
 - (ii) Компанийн оршин байгаа хаягийг Монгол Улс, Улаанбаатар 14220, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-гийн гудамж 31, Далай Тауэр, 11-н давхарт хэмээн өөрчлөх;
 - (iii) Компанийн Дүрмийг батлах;
 - (iv) Дор дурдсан нэр дэвшигчдийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн ердийн гишүүдээр сонгох. Үүнд:
 - (a) Адилбиш овогтой Ганхуяг;
 - (б) Адилбиш овогтой Ганболд;
 - (в) Гансүх овогтой Бат-Эрдэнэ;
 - (г) Очирбат овогтой Батмөнх;
 - (д) Ганболд овогтой Чинзориг; болон
 - (е) Болдбаатар овогтой Бат-Эрдэнэ;
 - (v) Дор дурдсан нэр дэвшигчдийг ТУЗ-ийн хараат бус гишүүдээр сонгох. Үүнд:
 - (a) Равжин овогтой Ганболд;
 - (б) Чулуун овогтой Мэргэн; болон

ДУГААР 151021-18
огноо 2021 оны 11-р сарын 17-ны өдөр

(в) Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo).







3. Хурлын зарыг 2021 оны 11-р сарын 22-ны өдөр, давтан зарыг 2021 оны 12-р сарын 07-ны өдөр тус тус өдөр тутмын сонин, Компани болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэсүгэй.
4. Хурлын зарыг Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
5. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 12-р сарын 10-ны өдрөөр тогтсугай.
6. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн цахим бүртгэлийг 2021 оны 12-р сарын 15-ны өдрийн 10:00 цагаас эхлэн 2021 оны 12-р сарын 25-ны өдрийн 16:00 цаг хүртэл <https://hural.cumongol.mn> веб хаягаар хийж, санал өгөх нууц кодыг хувьцаа эзэмшигчдийн гар утсанд илгээхээр шийдвэрлэсүгэй.
7. Хурлын санал хураалтыг <https://hural.cumongol.mn> веб хаягаар 2021 оны 12-р сарын 16-ны өдрийн 10:00 цагаас эхлэн 2021 оны 12-р сарын 26-ны өдрийн 16:00 цаг хүртэл урьдчилан цахимаар болон Хурлын үеэр цахимаар тус тус хүлээн авахаар шийдвэрлэсүгэй.
8. Хувьцаа эзэмшигчдийн Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр санал өгөх саналын хуудасны загварыг Хоёрдугаар хавсралтаар баталсугай.
9. Хурлын зарыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлсэн өдрөөс эхлэн Хурал хуралдуулахтай холбоотой дор дурдсан баримт бичигтэй танилцах боломжийг хувьцаа эзэмшигчдэд олгосугай. Үүнд:
 - (i) Хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн 2021 оны 11-р сарын 17-ны өдрийн 151021-18 тоот тогтоол;
 - (ii) Хурлын зар;
 - (iii) Хурлаас гарах шийдвэрийн төсөл;
 - (iv) Компанийн Дүрмийн төсөл;
 - (v) ТУЗ-д нэр дэвшигчдийн танилцуулга;
 - (vi) Хурлын саналын хуудас; болон
 - (vii) Хуралд оролцож, санал өгөх заавар.
10. Хурлын даргаар ТУЗ-ийн дарга А.Ганхуягийг томилсугай.
11. Дор дурдсан нэр бүхий ажилтнуудыг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
 - (i) Г.Чинзориг, Гүйцэтгэх захирал (дарга);

ДУГААР 151021-18
ОГНОО 2021 оны 11-р сарын 17-ны өдөр

- (ii) Т.Гантулга, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;
 - (iii) Г.Батбаатар, Бизнес хөгжлийн менежер;
 - (iv) Б.Ганзориг, Нягтлан бодох бүртгэлийн менежер; болон
 - (v) Б.Ууганболд, Маркетингийн ахлах мэргэжилтэн.
12. Дор дурдсан нэр бүхий хүмүүсийг Хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
- (i) Б.Лхамдолгор, Апекс Капитал ҮЦК ХХК-ийн Гүйцэтгэх захирал (дарга);
 - (ii) П.Сэлэнгэ, Апекс Капитал ҮЦК ХХК-ийн Хуульч; болон
 - (iii) Т.Энх-Амгалан, Апекс Капитал ҮЦК ХХК-ийн Брокер.
13. Хурлын материалыг 2021 оны 11-р сарын 22-ны өдөр брокерын компаниуд болох Голомт Капитал ХХК болон Апекс Капитал ХХК-д хүргүүлсүгэй.
14. Хувьцаа эзэмшигчид 2021 оны 12-р сарын 28-ны өдрийн 10:00 цагт Монгол Улс, Улаанбаатар хот 14241, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 19А, Шангри-Ла Худалдааны Төв, 4-р давхарт, Өргөө 3 кино театр, 4-р танхимд биечлэн ирж цахимаар санал өгөх боломж, бололцоог бүрдүүлэхийг Хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
15. Хурлын бэлтгэл ажлыг хангах, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах, энэ тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
16. Хурлын мэдэгдлийг 2021 оны 11-р сарын 19-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Т.Гантулга)-д үүрэг болгосугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана)

ДУГААР 151021-18
 ОГНОО 2021 оны 11-р сарын 17-ны өдөр

		ЗӨВШӨӨРӨН	ТАТГАЛЗСАН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:	А.ГАНХУЯГ		
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:	А.ГАНБОЛД		
	О.БАТМӨНХ		
	Г.БАТ-ЭРДЭНЭ		
	Г.ЧИНЗОРИГ		
Тогтоолын батлагдсан хувь:			

ДУГААР 151021-18
ОГНОО 2021 оны 11-р сарын 17-ны өдөр

Нэгдүгээр хавсралт

СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК

(Хувьцааны код: CUMN)

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ЗАР

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК ("Компани")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2021 оны 11-р сарын 17-ны өдрийн 18 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал ("Хурал")-ыг 2021 оны 12-р сарын 28-ны өдрийн 10:00 цагт <https://hural.cumongol.mn> веб хаягаар Zoom платформ ашиглан цахим хэлбэрээр хуралдуулна.

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн батална. Үүнд:

1. Компанийг хувьцаат компани болгох замаар хэлбэрийг өөрчлөх.
2. Компанийн оршин байгаа хаягийг Монгол Улс, Улаанбаатар 14220, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-гийн гудамж 31, Далай Тауэр, 11-н давхарт хэмээн өөрчлөх.
3. Компанийн Дүрмийг батлах.
4. Дор дурдсан нэр дэвшигчдийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн ердийн гишүүдээр сонгох. Үүнд:
 - (а) Адилбиш овогтой Ганхуяг;
 - (б) Адилбиш овогтой Ганболд;
 - (в) Гансүх овогтой Бат-Эрдэнэ;
 - (г) Очирбат овогтой Батмөнх;
 - (д) Ганболд овогтой Чинзориг; болон
 - (е) Болдбаатар овогтой Бат-Эрдэнэ.
5. Дор дурдсан нэр дэвшигчдийг ТУЗ-ийн хараат бус гишүүдээр сонгох. Үүнд:
 - (а) Равжин овогтой Ганболд;
 - (б) Чулуун овогтой Мэргэн; болон
 - (в) Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo).

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр нь 2021 оны 12-р сарын 10-ны өдөр байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн цахим бүртгэлийг 2021 оны 12-р сарын 15-ны өдрийн 10:00 цагаас эхлэн 2021 оны 12-р сарын 25-ны өдрийн 16:00 цаг хүртэл <https://hural.cumongol.mn> веб хаягаар хийж, санал өгөх нууц кодыг хувьцаа эзэмшигчдийн гар утсанд илгээнэ.

ДУГААР 151021-18
ОГНОО 2021 оны 11-р сарын 17-ны өдөр

Хурлын санал хураалтыг <https://hural.cumongol.mn> веб хаягаар 2021 оны 12-р сарын 16-ны өдрийн 10:00 цагаас эхлэн 2021 оны 12-р сарын 26-ны өдрийн 16:00 цаг хүртэл урьдчилан цахимаар болон Хурлын үеэр цахимаар тус тус хүлээн авна.

Хурлаас гарах шийдвэрийн төсөл болон түүнтэй холбогдох баримт бичгийг хавсаргав.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчид 2021 оны 12-р сарын 15–25-ны өдрийн (ажлын өдрүүдэд) 16:00–18:00 цагийн хооронд Монгол Улс, Улаанбаатар 14220, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-гийн гудамж 31, Далай Тауэр, 11-н давхарт хүрэлцэн ирж Хурал хуралдуулахтай холбоотой дор дурдсан баримт бичигтэй танилцах боломжтой. Үүнд:

1. Хурлыг зарлан хуралдуулах тухай Компанийн ТУЗ-ийн 2021 оны 11-р сарын 17-ны өдрийн 151021-18 тоот тогтоол,
2. Хурлын зар,
3. Хурлаас гарах шийдвэрийн төсөл,
4. Компанийн Дүрмийн төсөл,
5. ТУЗ-ийн гишүүд нэр дэвшигчдийн танилцуулга,
6. Хурлын саналын хуудас,
7. Хуралд оролцож, санал өгөх заавар.

Хурал зохион байгуулах комиссын даргаар Компанийн Гүйцэтгэх захирал Г.Чинзориг, гишүүдээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Гантулга, Бизнес хөгжлийн менежер Г.Батбаатар, Нягтлан бодох бүртгэлийн менежер Б.Ганзориг, Маркетингийн ахлах мэргэжилтэн Б.Ууганболд нар ажиллах бөгөөд Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчид Хуралд оролцож, санал өгөхтэй холбоотой мэдээллийг 2021 оны 12-р сарын 15–25-ны өдрийн (ажлын өдрүүдэд) 16:00–18:00 цагийн хооронд Хурал зохион байгуулах комиссоос 8610-6181, 8805-4321, 8810-3285 утсаар болон gantulga.t@cumongol.mn, batbaatar.g@cumongol.mn, ganzorig.b@cumongol.mn цахим шуудангаар авах боломжтой.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК
Хурал зохион байгуулах комисс

ДУГААР 151021-18
ОГНОО 2021 оны 11-р сарын 17-ны өдөр

Хоёрдугаар хавсралт

СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХХК
(Хувьцааны код: CUMN)

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС

Хувь хүний овог, нэр/Байгууллагын оноосон нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй энгийн хувьцааны тоо: _____

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК (“Компани”)-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (“Хурал”)-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн цахим бүртгэлийг 2021 оны 12-р сарын 15-ны өдрийн 10:00 цагаас эхлэн 2021 оны 12-р сарын 25-ны өдрийн 16:00 цаг хүртэл <https://hural.cumongol.mn> веб хаягаар хийж, санал өгөх нууц кодыг хувьцаа эзэмшигчдийн гар утсанд илгээнэ.

Хурлын санал хураалтыг <https://hural.cumongol.mn> веб хаягаар 2021 оны 12-р сарын 16-ны өдрийн 10:00 цагаас эхлэн 2021 оны 12-р сарын 26-ны өдрийн 16:00 цаг хүртэл урьдчилан цахимаар болон Хурлын үеэр цахимаар тус тус хүлээн авна.

Хувьцаа эзэмшигчид 2021 оны 12-р сарын 28-ны өдрийн 10:00 цагт Монгол Улс, Улаанбаатар хот 14241, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 19А, Шангри-Ла Худалдааны Төв, 4-р давхарт, Өргөө 3 кино театр, 4-р танхимд биечлэн ирж цахимаар санал өгөх боломжтой.

Хувьцаа эзэмшигч өөр хүнээр төлөөлүүлэн санал өгөх бол тухайн төлөөлөх хүнд итгэмжлэл олгож нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн Хурлын санал хураалтад хүчинтэй байна.

ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ		ЗӨВШӨӨРСӨН (Санамж 1)	ТАТГАЛЗСАН (Санамж 1)	ТҮДГЭЛЗСЭН (Санамж 1)
1.	Компанийг хувьцаат компани болгох замаар хэлбэрийг өөрчилсүгэй.			
2.	Компанийн оршин байгаа хаягийг Монгол Улс, Улаанбаатар 14240, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-гийн гудамж 31, Далай Тауэр, 11-н давхарт хэмээн өөрчилсүгэй.			
3.	Компанийн Дүрмийг баталсугай.			
Санамж 1:				

ДУГААР 151021-18
ОГНОО 2021 оны 11-р сарын 17-ны өдөр

“Зөвшөөрсөн”, “Татгалзсан” эсвэл “Түдгэлзсэн” ээ илэрхийлж харгалзах нэг нүдэнд тэмдэглэгээг хийж санал аа өгнө.

ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ		НЭР ДЭВШИГЧИД ӨГӨХ САНАЛЫН ТОО (Санамж 2)
Дор дурдсан нэр дэвшигчдийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн ердийн гишүүдээр сонгох. Үүнд:		
4.(а)	Адилбиш овогтой Ганхуяг	
4.(б)	Адилбиш овогтой Ганболд	
4.(в)	Гансүх овогтой Бат-Эрдэнэ	
4.(г)	Очирбат овогтой Батмөнх	
4.(д)	Ганболд овогтой Чинзориг	
4.(е)	Болдбаатар овогтой Бат-Эрдэнэ	
Дор дурдсан нэр дэвшигчдийг ТУЗ-ийн хараат бус гишүүдээр сонгох. Үүнд:		
4.(ё)	Равжин овогтой Ганболд	
4.(ж)	Чулуун овогтой Мэргэн	
4.(з)	Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo)	
<p>Санамж 2:</p> <p>ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн нэг хувьцаа нь Компанийн Дүрмээр тогтоосон ТУЗ-ийн нийт гишүүдийн тоотой тэнцүү саналын эрхтэй байна. Хувьцаа эзэмшигч саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.</p> <p>Тухайлбал, хувьцаа эзэмшигч А нь Компанийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон. Хувьцаа эзэмшигч А-гийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй. Жишээ нь:</p> <p>Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.</p> <p>Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно.</p>		

Хувьцаа эзэмшигчийн баталгаажуулалт:

Огноо: